

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын “Цоожэд” ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/3/СТА-ТБОНӨААН

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn</p> <p>Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
БГБХ	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай
НББ	Нягтлан бодох бүртгэл
НӨАТ	Нэмэн өртгийн албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	13
3.7. Бүх гишүүдийн бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа	13
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.10. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа	14
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	Error! Bookmark not defined.

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.03.15 № 117
Танай _____-ны № _____ т

БУЛГАН СУМЫН “ЦООЖИД”
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.ДОЛГОР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цоожид” ӨЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчил нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Бараа материалын нярвын тайланд 19207.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэл, 17671.9 мянган төгрөгийн эцсийн үлдэгдлийг тусгаагүй, санхүүгийн тодруулга тайланд 8233.7 мянган төгрөгийн орлого, 6698.5 мянган төгрөгийн зарлага дутуу, жолоочийн тооцооны хуудас, вакцины тайлан, эмийн тайланг архивын нэгж болгоогүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3-т Нягтлан бодох

006000215

бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ; 14.3.1 анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2 журналд бичих, 14.3.3 дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4 ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5 санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн, УСНББОУС-12 мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн аудитын толилуулга ба тодруулга, хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19619463.71	26097932.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20000.00	627400.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	20000.00	627400.00
3121	Төгрөг	20000.00	627400.00
31213	Арилжааны банк дахь харилцах	20000.00	627400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19599463.71	25470532.09
351	Түүхий эд материал	4443402.53	11375470.91
35110	Тусгай зориулалттай материал	2151000.00	2151000.00
35130	Эм боох материал	2292402.53	9224470.91
354	Хангамжийн материал	15156061.18	14095061.18
35410	Бичиг хэргийн материал	371000.00	1147400.00
35420	Аж ахуйн материал	14785061.18	12947661.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	149465499.61	179066323.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	149465499.61	179066323.44
392	Биет хөрөнгө	139697499.61	169298323.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	129848080.89	132348080.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	5891254.74	8245009.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7500000.00	1200000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	6640625.00	0.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31114446.75	49069924.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	19720291.27	9758481.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7188400.00	7753400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	3701257.02	3069591.90
393	Биет бус хөрөнгө	9768000.00	9768000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9768000.00	9768000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	169084963.32	205164255.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	316000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	316000.00
413	Өглөг	0.00	316000.00
4136	Бусад өглөг	0.00	316000.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/		316000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	169084963.32	204848255.53
51	Засгийн газрын хувь оролцоо	169084963.32	204848255.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	41165780.27	41165780.27
51101	Өмч: - төрийн	41165780.27	41165780.27
512	Хуримтлагдсан үр дүн	85357100.56	121120392.77
51210	Өмнөх үеийн үр дүн	84912936.14	85357100.56
51220	Тайлант үеийн үр дүн	444164.42	35763292.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42562082.49	42562082.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	169084963.32	205164255.53

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	111429725.13	209400286.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	111429725.13	209400286.63
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	93954892.00	180004540.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	93954892.00	180004540.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11481333.13	24146846.63
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ / вакцин ЭМГазараас/	11411333.13	22768846.63
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ЭМГазараас	50000.00	100000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих/ ЭМГазар шүүхийн шийдвэр/	20000.00	1278000.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	3760000.00
133003	Хөрөнгийн		3760000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5993500.00	1488900.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5993500.00	1488900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	109730093.92	173636994.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	109730093.92	168863894.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	109462093.92	168593894.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66433788.00	96539786.00
210101	Үндсэн цалин	66433788.00	96539786.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8364922.92	5280502.03
210201	Тэтгэврийн даатгал	8364922.92	5280502.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2897881.00	3017955.00
210301	Гэрэл, цахилгаан	478381.00	541755.00
210302	Түлш, халаалт	2419500.00	2420000.00
210303	Цэвэр, бохир ус		56200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4230204.01	7226460.57
210401	Бичиг хэрэг	372550.00	1922946.00
210402	Тээвэр, шатахуун	530175.00	555250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	578711.01	622862.57
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	316000.00	393500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2432768.00	3731902.00
2105	Нормативт зардал	12286919.14	31251770.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12286919.14	31251770.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1720800.00	5520600.00
210604	Урсгал засвар	1720800.00	5520600.00
2107	Томилолт, зочны зардал	292644.00	495600.00
210702	Дотоод албан томилолт	292644.00	495600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1378498.00	3407364.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1033793.00	2867748.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	103400.00	111600.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	241305.00	428016.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11856436.85	15853855.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1456200.00	1778200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4759700.00	8578600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5640536.85	5497055.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	268000.00	270000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	268000.00	270000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	268000.00	270000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	4773100.28
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	4773100.28

225102	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/		4773100.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1699631.21	35763292.21
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1255466.79	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1255466.79	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1255466.79	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	444164.42	35763292.21

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТ-4А

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	201 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	201 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,165,780.27	42,562,082.49	85,357,100.56	0.00	169,084,963.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			35,763,292.21		35,763,292.21
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,165,780.27	42,562,082.49	121,120,392.77	0.00	204,848,255.53

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СТ-2А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	100018392.00	182871440.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	100018392.00	182871440.00

**“Цоожэд” ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	93954892.00	180004540.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	93954892.00	180004540.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50000.00	1378000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	50000.00	100000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих ЭМГазар шүүхийн шийдвэр		1278000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5993500.00	1488900.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5993500.00	1488900.00
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	98501052.00	150803060.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98501052.00	150803060.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97991747.00	150105044.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66433788.00	96539786.00
210101	Үндсэн цалин	66433788.00	96539786.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8339854.99	5280502.03
210201	Тэтгэврийн даатгал	8339854.99	5280502.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2897881.00	2896455.00
210301	Гэрэл, цахилгаан	478381.00	541755.00
210302	Түлш, халаалт	2419500.00	2298500.00
210303	Цэвэр, бохир ус		56200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4230204.01	10620960.57
210401	Бичиг хэрэг	372550.00	2699346.00
210402	Тээвэр, шатахуун	530175.00	555250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	578711.01	622862.57
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	316000.00	393500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2432768.00	6350002.00
2105	Нормативт зардал	2769000.00	15414992.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2769000.00	15414992.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3273800.00	5520600.00
210602	Тавилга	1553000.00	
210604	Урсгал засвар	1720800.00	5520600.00
2107	Томилолт, зочны зардал	292644.00	495600.00
210702	Дотоод албан томилолт	292644.00	495600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1387675.00	2979348.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1284275.00	2867748.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	103400.00	111600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8366900.00	10356800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1456200.00	1778200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6910700.00	8578600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	509305.00	698016.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	509305.00	698016.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	241305.00	428016.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	268000.00	270000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1517340.00	32068380.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1769700.00	31460980.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1769700.00	31460980.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1769700.00	31460980.00
220001	Тоног төхөөрөмж	1769700.00	31460980.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1769700.00	-31460980.00
8	НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-252360.00	607400.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	272360.00	20000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20000.00	627400.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101298392.00	100270752.00	203500640.00	182264040.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99498392.00	98501052.00	171700640.00	150803060.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98933087.00	97991747.00	170772624.00	150105044.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66598399.00	66433788.00	110032644.00	96539786.00
210101	Үндсэн цалин	66598399.00	66433788.00	110032644.00	96539786.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8354788.00	8339854.99	6892300.00	5280502.03
210201	Тэтгэврийн даатгал	8354788.00	8339854.99	6892300.00	5280502.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3058200.00	2897881.00	3915000.00	2896455.00
210301	Гэрэл, цахилгаан	523200.00	478381.00	680000.00	541755.00
210302	Түлш, халаалт	2535000.00	2419500.00	3150000.00	2298500.00
210303	Цэвэр, бохир ус			85000.00	56200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4504000.00	4230204.01	13402000.00	10620960.57
210401	Бичиг хэрэг	416000.00	372550.00	2778500.00	2699346.00
210402	Тээвэр, шатахуун	560000.00	530175.00	620000.00	555250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	624000.00	578711.01	685000.00	622862.57
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	338000.00	316000.00	464000.00	393500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2566000.00	2432768.00	8854500.00	6350002.00
2105	Нормативт зардал	2867000.00	2769000.00	15812000.00	15414992.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2867000.00	2769000.00	15812000.00	15414992.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3326000.00	3273800.00	5698500.00	5520600.00
210602	Тавилга	1570000.00	1553000.00		
210604	Урсгал засвар	1756000.00	1720800.00	5698500.00	5520600.00
2107	Томилолт, зочны зардал	330000.00	292644.00	652000.00	495600.00
210702	Дотоод албан томилолт	330000.00	292644.00	652000.00	495600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1422000.00	1387675.00	3183180.00	2979348.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1310000.00	1284275.00	3060580.00	2867748.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	112000.00	103400.00	122600.00	111600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8472700.00	8366900.00	11185000.00	10356800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1562000.00	1456200.00	1985000.00	1778200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6910700.00	6910700.00	9200000.00	8578600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	565305.00	509305.00	928016.00	698016.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	565305.00	509305.00	928016.00	698016.00

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	241305.00	241305.00	428016.00	428016.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	324000.00	268000.00	500000.00	270000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1800000.0	1769700.0	31800000.0	31460980.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1800000.0	1769700.0	31800000.0	31460980.0
222001	Тоног төхөөрөмж	1800000.00	1769700.00	31800000.00	31460980.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	101298392.00	100018392.00	203500640.00	182871440.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	93954892.00	93954892.00	180004540.00	180004540.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	93954892.00	93954892.00	180004540.00	180004540.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5993500.00	5993500.00	21996100.00	1488900.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5993500.00	5993500.00	21996100.00	1488900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1350000.00	70000.00	1500000.00	1378000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1350000.00	70000.00	1350000.00	1378000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		272360.00		20000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		20000.00		627400.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	10.00	17.00	13.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	6.00	13.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	3.00	3.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган сумын “Цоожэд” ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг Б.Долгор танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгө бэлтгэхдээ холбогдох тушаалуудын дагуу худалдан авсан боловч нөхөрлөлийн хурлаар авч хэлэлцэн шийдвэрлээгүй, Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5292:2017-ын 7.8-7.12-д тусгагдаагүй дарга, архив, бичиг хэргийн ажилтны орон тоог баталж цалин олгосон, тендерт шалгараагүй аж ахуй нэгж байгууллагаас 8.9 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан, 19.4 сая төгрөгийн төлбөрийн баримтгүй худалдан авалт хийсэн, шилэн дансны тухай хуулийг бүрэн хангаж ажиллаагүй талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

“Цоожэд” ӨЭМТ-ийн Булган аймаг дахь төрийн аудитын газар-т 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Цоожэд” БГБХ нөхөрлөл гэсэн статустай байна. Өмчийг бүрэн бус нөхөрлөлийн гишүүд эзэмшиж байна.

“Цоожэд” өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төв нь эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтын дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээг иргэдэд үнэ төлбөргүй, чанартай, хүртээмжтэй үзүүлнэ
- Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлж, шаардлагатай лавлагаа, тусламжийг цаг алдалгүй зохион байгуулан тусламж үйлчилгээг тасралтгүй иргэдэд тусламж үйлчилгээг мөн адил тэгш хүртээмжтэй үзүүлнэ.
- Гамшиг осол, нийтийг хамарсан халдварт өвчний үед аймгийн онцгой байдлын комисс, эрүүл мэндийн газрын шийдвэрийн дагуу тусламж үйлчилгээ үзүүлнэ.
- Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандан судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулан, үр дүнг тооцож ажиллана.
- Эрүүл мэндийг дэмжигч иргэн, өрх, байр, гудамж байгууллага боох хөдөлгөөнийг өрнүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

“Цоожэд” ӨЭМТ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

“Цоожэд” ӨЭМТ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны мөнгөн гүйлгээний тайлангийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 173.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Цоожэд” ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36.1 сая төгрөгөөр буюу 21.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.02	0.63	0.61
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	19.60	25.47	5.87
Үндсэн хөрөнгө	149.47	179.07	29.60
Нийт хөрөнгийн дүн	169.08	205.16	36.08
Өр төлбөр	0	0.32	0.32
Эздийн өмч	169.08	204.85	35.76
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	169.08	205.16	36.08

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн данстад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Бараа материалын дансны үлдэгдэл 25.5 сая төгрөг болж 5.9 сая төгрөгөөр өссөн нь эм боох материалын 9.2 сая төгрөгийн үлдэгдэл нь ковид-19 цар тахлаас шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 31.9 сая төгрөг, Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 22.8 сая төгрөгийн вакцин нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 179.1 сая төгрөг болж 29.6 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө бэлтгэснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь өөрийн хөрөнгөөр худалдан авсан 31.5, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг үнэлж ашиглалтын хугацааг тодорхойлсноор 6.8 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн 3.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.3 сая төгрөг болж 0.3 сая төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ыг татварын байгууллагад шилжүүлээгүйгээс шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 204.8 сая төгрөг болж 35.8 сая төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө бэлтгэсэн, бараа материалын зарцуулалт багаас шалтгаалжээ.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн 2020 оны төсвийн төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 203.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 203.5 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 182.9 сая төгрөгийн орлого орж, 182.3 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь тусгай зориулалтын шилжүүлгээс 180.0 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 21.9 сая, үндсэн үйл ажиллагаанаас 1.4 сая төгрөг бүрдэхээс тусгай зориулалтын шилжүүлгээс 180.0 сая, эрүүл мэндийн сангаас 1.5 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.4 сая төгрөг нийт 182.9 сая буюу 20.7 сая төгрөгийг дутуу бүрджээ

Нийт орлогын гүйцэтгэл 203.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 182.9 сая төгрөг буюу 10.1 хувиар тасарсан нь НДС-аас 20.5 сая, үйл ажиллагаанаас 0.1 сая төгрөгийг дутуу буюу НДС-аас зарим эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээний биелэлт хангалтгүйгээс шалтгаалж голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 182.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 21.2 сая төгрөг буюу 19.8 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь гэрээний биелэлтээс шалтгаалж орлого /санхүүжилт/ дутуу орсон шалтгаан гол нөлөө үзүүлсэн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

3.7. Бүх гишүүдийн бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Бүх гишүүдийн бүрэн хариуцлагатай нөхөрлөл нь хуульд заасны дагуу нийт 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нөхөрлөлийн хурлыг 2020 онд 9 удаа зохион байгуулж 13 асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд ББН-ийн үйл ажиллагаа, засаглалтай холбоотой дүрмийг шинэчлээгүй, журмыг нөхөрлөлийн 2017 оны бүх ажилчдын хурлаар баталжээ.

2020 онд БН-ийн үйл ажиллагааны зардалд нийт 203.5 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 182.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 96.5, ажил олгогчоос НДШ-д 5.3, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2.9, хангамж бараа материалын зардалд 10.6, нормативд зардалд 15.4, эд хогшил урсгал засварт 5.5, томилолтын зардалд 0.5, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжид 2.9, бараа үйлчилгээний бусад зардалд 10.4, нэг удаагийн болон НД-ийн тэтгэвэр, тэтгэмжийн зардалд 0.7 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 125 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 24 мэдээллийг хугацаа хоцроож, 30 тушаал, шийдвэрийн мэдээллийг байршуулаагүй байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	2	2.1	2	2.1	100
Албан шаардлага	2	22.6	2	22.6	100
Зөвлөмж	5	22.5	5	22.5	100
Нийт дүн	9	47.2	9	47.2	100

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.4 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 26.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулгыг хийгээгүй болно.

Төлбөрийн акт, албан шаардлага

1. Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны Б/22 тоот тушаалаар 8 албан хаагчдад нийт 1.3 сая төгрөгийн илүү цагийн хөлс тооцож олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна", 4-т "Төрийн албан

хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл тус бүрээр бичнэ” гэсэн заалтыг зөрчин нийт 0.4 сая төгрөгийг илүү тооцон олгосон нь үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлт болон үйл ажиллагаа явуулах гурван талт гэрээ, түүний биелэлт, үнэлгээг үзэх шаардлагатай

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Нярвын тайланд 19.2 сая төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэл, 17.7 сая төгрөгийн эцсийн үлдэгдлийг тусгаагүй, 8.2 сая төгрөгийн орлого, 6.7 сая төгрөгийн зарлагын журнал бичилт тус тус дутуу, жолоочийн тооцооны хуудас, вакцины тайлан, эмийн тайланг архивын нэгж болгоогүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1 анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2 журналд бичих, 14.3.3 дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4 ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5 санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн, УСНББОУС-12 мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл: Тайлан буруу илэрхийлэгдэх

1.3 Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 13.1, 14.3 дахь заалтыг хэрэгжүүлэх, УСНББОУС-12 мөрдөх

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Нийт 31.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэхдээ холбогдох тушаалуудын дагуу худалдан авсан боловч нөхөрлөлийн хурлаар авч хэлэлцэн шийдвэрлээгүй нь Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, "Цоожэд" өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн 2.4, 6.1.8-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх

2.3. Өгсөн зөвлөмж: Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, "Цоожэд" өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн 2.4, 6.1.8-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Бүтэц орон тоотой холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Бүтэц орон тоог "Цоожэд" ББН-ийн 2020 оны 01 дүгээр сарын 30-ны 01 дүгээр хурлаар нийт 12.5 байхаар баталсан байна. Тус өрхийн эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний Б/01 тушаалаар орон тоог 17-оор буюу 4.5-аар

“Цоожэд” ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

зөрүүтэй баталсан нь Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5292:2017-ын 7.8-7.12-д тусгагдаагүй дарга, архив, бичиг хэргийн ажилтны орон тоог баталж цалин олгосон байна.

3.2. Эрсдэл: Үргүй зардал гарах, ажлын ачаалал жигд бус байх, стандарт дүрэм зөрчигдөх

3.3. Өгсөн зөвлөмж: Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5292:2017-ын дагуу бүтэц орон тоог нөхөрлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж батлах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Зарлага холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд нийт 15.4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэснээс тендерт шалгараагүй аж ахуй нэгж байгууллагаас 8.9 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан нь санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл: Иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, ашиг сонирхлын зөрчил үүсэх

4.3. Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

5. Худалдан авалттай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр 19.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн.

5.2. Эрсдэл: Орлогыг нуун дарагдуулах, тайлагнахгүй байх

5.3. Өгсөн зөвлөмж: НӨАТТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

6. Шилэн данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт: Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбарыг мэдээлээгүй, хугацаа хоцроосон 24 мэдээлэл, 30 тушаал шийдвэр мэдээлээгүй байна.

6.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, хариуцлага хүлээх

6.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.4.8, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.3.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР

Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

А.СУВДАА